



МОНГОЛ АЛТ

“МОНГОЛ АЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 05 өдөр

№ 02

Дархан уул аймаг

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, “Монгол Алт” хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3, 7.5, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өрдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Монгол Алт” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2022 оны 04 сарын 20-ны өдрийн 11:00 цагт Монгол Улс, Дархан-Уул аймаг 7-р баг “Монгол Алт” ХК-ний хурлын танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хурал зарлах тухай мэдэгдлийг 2022 оны 03 сарын 07-ны өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2022 оны 03 сарын 10-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2022 оны 03 сарын 26-ны өдрийн дотор анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 03 сарын 31-ний өдрөөр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2022 оны 03 сарын 15-ны өдрөөс өмнө үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал М.Цолмонд үүрэг болгосугай.
6. Хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Дорждэрэмийг томилсугай.
7. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:
  1. Хурал зохион байгуулах комиссын дарга:
    1. Б.Саруул
  2. Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
    1. Б.Батжаргал
8. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг НЭГДҮГЭЭР хавсралтаар, саналын хуудасны загварыг ХОЁРДУГААР хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарыг ГУРАВДУГААР хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг ДӨРӨВДҮГЭЭР хавсралтаар тус тус баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн санал хүлээн авах эцсийн хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 09:00 цаг байхаар тогтоосугай.

10. Хувьцаа эзэмшигчдийг Хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс Б.Саруулд даалгасугай.
11. Хурлын тооллогын комиссыг дараахи бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
  1. Хурлын тооллогын комиссын дарга:
    1. Ж.Мягмарцэцэг
  2. Хурлын тооллогын комиссын гишүүд:
    1. Л.Нарангэрэл

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА - 2



С.ДОРЖДЭРЭМ